





2019 оны 10 дугаар сарын 21-25

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **981** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 114(11.7%) галзуугийн эрсдэлд өртсөн, 836(85.2%) хачигт халдвар, 7(0.7%) боом, 7(0.7%) тарваган тахал, 3(0.3%) хумхаа, (0.1%) ям, 5(0.5%) денги, 5(0.5%) бэтэг, 3(0.3%) бруцеллез өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:



Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 22 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 114 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8%-иар нэмэгдсэн байна. Эпидемиологийн 42 дугаар долоо хоногтой харьцуулахад 2 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. **Энэ долоо хоногт сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй байна.**



Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл эзэнтэй нохойд (39.4%), чононд (18.3%), эзэнгүй нохойд (14.4%), үнэгэнд (8.7%), үхэрт (7.7%), мануулд (2.9%), мууранд (1.9%), тэмээнд (1.0%) нь уруулж, ноцуулж вакцин, ийлдэс эмчилгээнд хамрагдсан байна

1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Сүхбаатар аймгийн 116 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 836 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 23.4%-иар буурсан байна. Эпидемиологийн 42 дугаар долоо хоногтой харьцуулахад 5 тохиолдлоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. **Энэ долоо хоногт 2 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн.**



2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар ХР-ын 671 сэжигтэй тохиолдлын 135(20.1%), ХБ-ын 74 сэжигтэй тохиолдлын 17(23.0%), ХЭ-ын 91 сэжигтэй тохиолдлын 18(19.8%) нь тархвар судлал, эмнэл зүй, лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан.

1.3 Мэрэгч амьтны дуудлага:

Он гарсаар нийслэлийн 5 дүүргийн (БЗД, БГД, СХД, СБД, ХУД) хэмжээнд нийт 83 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

Энэ долоо хоногт Нийслэлийн СХД-ийн “Эмээлт” АТШН товчооноос ирүүлсэн мэрэгч амьтны (тарвага-6) 3 удаагийн дуудлаганд үйлчилсэн. Сорьц материалыг шинжилж байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мал, амьтны өвчлөл:



2019 оны 10 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд мал, амьтны өвчлөл бүртгэгдээгүй байна.

Эх сурвалж: ОБЕГ

Олон улсад:

Эбола вируст халдвар:

2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вируст халдварын сэжигтэй тохиолдол 3227 тохиолдол бүртгэгдсэнээс 2154 (67%) нь нас барсан. Нийт тохиолдлын 1811 (56%) нь эмэгтэйчүүд, 918 (28%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзэлж байна.



Зураг 1. Эбола вируст халдварын тархалт, БНАК улс

Гахайн сонгомол мялзан өвчин:

Бразил улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 10 дугаар сарын 03-нд Алагоас мужид гахайн сонгомол мялзан өвчин бүртгэгдэж, 6 гахайг устгасан байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Мал, амьтны галзуугийн өвчлөл:


Малайз улсын Сарабак мужийн Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Кучинг хотын нэгэн тосгонд мал, амьтны өвчлөл бүртгэгдэж, өвчилсөн 1 муурыг устгасан байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчний мэдээллийн 7 хоног бүрийн мэдээгээр 2019 оны 10 дугаар сарын 20-ны өдөр нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Хэл хөхрөх өвчин:


Грек улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Хойд Эгейн тосгоны фермд Хэл хөхрөх өвчин бүртгэгдэж, 250 хонь өртөмхий байснаас 1 хонь өвчилсөн байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.




Эх сурвалж: ДМАЭМБ

Ласса чичрэг өвчин:

Нигери улсын Өвчний Хяналт Сэргийлэлтийн Төвийн 41 дүгээр долоо хоногийн эргэн мэдээллээр 2019 оны 10 дугаар сарын 07-13-ны хооронд Ласса чичрэг өвчний сэжигтэй 4 тохиолдол бүртгэгдсэн байна.



Тус улсад 2019 оны 01 дүгээр сарын 01-ээс 10 дугаар сарын 13-ны өдрийг хүртлэх хугацаанд Нигери улсын 23 мужаас Ласса чичрэг өвчний 4099 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 726 тохиолдол батлагдаж, 154 (21.2%) нь нас барсан байна.



Эх сурвалж: Promed

Африкийн гахайн мялзан өвчин:

Эх сурвалж	Хаана	Мэдээлсэн хугацаа	Өртсөн хугацаа	Нэгж	Өртөмхий	Өвчилж үхсэн	Устгасан
ДМАЭМБ	• Молдав улс • Гахул тосгон	2019.10.21	2019.10.05	Ойд		1 зэрлэг гахай	
ДМАЭМБ	• Өмөнд Солонгос • Gyeonggi-Do	2019.10.22	2019.10.19	Ойд		1 зэрлэг гахай	
ДМАЭМБ	• Болгар улс • Veliko Tarnovo тосгон	2019.10.22	2019.10.22	Ойд		1 зэрлэг гахай	
ДМАЭМБ	• Украин улс • Полдав муж	2019.10.23	2019.10.21	Тодорхойгүй		1 гахай	
ДМАЭМБ	• ОХУ • Приморский край	2019.10.23	2019.10.17	Ойд		1 зэрлэг гахай	